



2025

Эхний хагас
жилийн тайлан
2025.07.21

“Кредитех СТМ ББСБ” ХХК-ийн
2025 оны эхний хагас жилийн
санхүү, үйл ажиллагааны тайлан



АГУУЛГА

01 БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

02 САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

03 ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

04 ЗОХИСТОЙ ХАРЬЦАА

05 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

06

Бизнесийн үйл ажиллагаа

“Кредитех СТМ ББСБ” ХХК нь 2014 онд байгуулагдсан цагаасаа хойш Монгол Улсын санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй, тогтвортой өсөлт бүхий хариуцлагатай санхүүгийн байгууллага юм. Бид харилцагч төвтэй үйлчилгээ, дижитал технологид суурилсан шийдлүүдийг эрэлхийлж, хүртээмжтэй санхүүгийн үйлчилгээний жишгийг шинэ шатанд хүргэхийг зорин ажиллаж байна.

Манай байгууллага нь хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон бичил бизнес эрхлэгчдэд чиглэсэн зээлийн бүтээгдэхүүнийг харилцагчдад хүртээмжтэй, илүү хялбар болгох үүднээс байгууллагын албан ёсны вебсайтаар дамжуулан зээлийн хүсэлт хүлээн авах цахим системийг нэвтрүүлэн ажиллуулж байна. Энэхүү цахим хүсэлтийн хэсэг нь зээлийн тооцоолуурын хамт ажиллаж, зээл хүсэгч тухайн нөхцөл байдалдаа үндэслэн хэдий хэмжээний зээл авах боломжтойгоо урьдчилан харах боломжийг олгодог.

Энэхүү шийдэл нь харилцагчдад илүү тодорхой, хялбар хэрэглээний туршлага олгож, зээлийн хүсэлтийг шуурхай хүлээн авч, богино хугацаанд шийдвэрлэх боломжийг нэмэгдүүлж, байгууллагын үйл ажиллагааны үр ашиг, харилцагчийн сэтгэл ханамжийг зэрэг ахиулж байна.

2025 оноос эхлэн бид нийгмийн болон байгаль орчны тогтвортой хөгжилд чиглэсэн бүтээгдэхүүний шугамыг өргөжүүлж:



- Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зээл
- Ногоон зээл зэрэг шинэ төрлийн бүтээгдэхүүнүүдийг боловсруулан нэвтрүүлээд байна.

Эдгээр зээлийн бүтээгдэхүүнүүд нь эдийн засгийн идэвхтэй бүлгийг дэмжихийн зэрэгцээ нийгмийн тэгш байдал, байгаль орчны хариуцлагыг дэмжих зорилготой юм.

санал болгож, олон нийтийн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого хэрэгжүүлж байна.

Зээлийн үйл ажиллагаа

Манай байгууллага нь иргэд болон жижиг, дунд бизнес эрхлэгчдэд санхүүгийн хэрэгцээтэй үед нь шуурхай, хялбар нөхцөл бүхий зээлийн бүтээгдэхүүнүүдийг санал болгож, олон нийтийн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого хэрэгжүүлж байна.



Санхүүгийн үзүүлэлтүүд

Орлого, үр дүнгийн хураангуй тайлан /аудитлагдаагүй/

Орлого, үр дүнгийн хураангуй тайлан /сая төгрөгөөр/	2023 II	2024 II	2025 II
Нийт орлого	504.6	719.8	1,354
Хүүгийн зардал	183.8	402.4	611.5
Цэвэр орлого	320.7	317.3	742.9
Зээлийн үйл ажиллагаатай холбоотой зардал	22.06	-	3.01
Зээлийн болзошгүй эрсдлийн нөөцийн зардал	-	-	-
Үйл ажиллагааны цэвэр орлого	46.6	37.9	121.1
Удирдлагын болон Ү/А-ны зардал	272.8	264.9	302.8
Татварын өмнөх ашиг	72.5	90.4	558.2
Татварын зардал	7.2	9.04	55.8
Цэвэр ашиг	65.2	81.3	502.4

2025 оны II улиралд “Кредитех СТМ ББСБ” ХХК нь 1.35 тэрбум төгрөгийн нийт орлого, 502.4 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, өмнөх онуудтай харьцуулахад орлого, ашигт ажиллагаа өссөн байна. Нийт хөрөнгө 2023 онд 5.96 тэрбум, 2024 онд 8.93 тэрбум төгрөг байсан бол 2025 онд 12.94 тэрбум төгрөгт хүрч, зээлийн багц 2.3 дахин өссөн үзүүлэлттэй байна. Өр төлбөр нийт хөрөнгийн 0.7%-ийг эзэлж, эзэмшигчийн өмч 3 жилийн хугацаанд 3 дахин нэмэгдсэн нь компанийн санхүүгийн тогтвортой, өсөлттэй байдлыг харуулж байна.

Санхүү байдлын тайлан /аудитлагдаагүй/

Санхүү байдлын тайлан	2023 II	2024 II	2025 II
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	177.9	170.04	104.6
Зээлийн багц (цэвэр)	5,525	8,694	12,794
Бусад хөрөнгө	119.1	18.9	20.1
Үндсэн хөрөнгө	23.3	50.8	24.8
Биет бус хөрөнгө	-	-	-
Нийт хөрөнгө	5,956	8,934	12,944
Өр төлбөр болон эздийн өмч	2023 II	2024 II	2025 II
Өр төлбөр	-	24.02	96.5
Эх үүсвэр	2,912	5,328	4,628
Бусад өглөг	-	-	-
Хоёрдогч өглөг	-	-	-
Эздийн өмчийн дүн	2,500	3,500	7,700
Хувьцаат капитал	-	-	-
Хуримтлагдсан ашиг	433.4	81.3	502.4
Бусад өөрийн хөрөнгө	-	-	16.8
Нийт өр төлбөр болон эздийн өмч	5,845	8,934	12,944

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

2025 оны II улирлын байдлаар манай байгууллага нь Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн ханган ажиллаж байна.

Тайлант хугацаанд нийт 12.79 тэрбум төгрөгийн зээлийн багцын хэмжээнд 128.1 хувийн түвшинд зээлийн эрсдэлийн нөөцийг бүрдүүлсэн нь чанаргүй зээлийн хэмжээг давж, зохицуулагчийн шаардлагыг хангаж буйг илтгэнэ.

Санхүүгийн тайланд тусгагдсанаар байгууллагын нийт хөрөнгө 12.94 тэрбум төгрөг, өөрийн хөрөнгө 7.7 тэрбум төгрөг байна. Өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа 59.5 хувь, өөрийн хөрөнгө, зээлийн багцын харьцаа 60.2 хувь байгаа нь зохицуулагчийн тогтоосон доод шаардлагууд болох тус бүр 10.0 болон 24.7 хувийг хангаад зогсохгүй, давуулан биелүүлж байна.

Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө 104.6 сая төгрөг байгаа нь төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг 108.4 хувийн түвшинд хадгалж, 8.9 хувийн доод шаардлагыг ханган ажиллаж байна. Манай байгууллага нь зээлийн эрсдэлийн удирдлагын бодлого, дотоод хяналтын тогтолцоог мөрдөн, зохистой харьцааны үзүүлэлтүүдийг тогтмол хянаж, шаардлагатай түвшинд байлгах замаар санхүүгийн тогтвортой байдлыг хадгалан ажиллаж байна.




Онцлох үйл явдлууд

“Хүүхэд бүр НЭГ мод” санаачилгыг хамтран эхлүүллээ.

"Кредитех СТМ ББСБ" ХХК нь НҮБ-ын Хүүхдийн Сан (UNICEF Mongolia) болон Тэрбум Мод Сантай хамтран “Хүүхэд бүр НЭГ мод” санаачлагыг хамтран хэрэгжүүлэхээр 5 жилийн хугацаатай Санамж бичигт гарын үсэг зурлаа.



Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд 500 сургуулийн цэцэрлэгийн орчинд ойжуулалт, цэцэрлэгжүүлэлтийн ажил хийх 280,000 хүүхдэд ойн болон цэцэрлэгжүүлэлтийн боловсрол олгох, байгальд ээлтэй, ногоон ирээдүйг хамтдаа бүтээх зорилготой юм.



Компанийн засаглал

“Кредитех СТМ ББСБ” ХХК нь Монгол Улсын хууль, холбогдох дүрэм журмыг чанд мөрдөн, Санхүүгийн зохицуулах хороо болон бусад зохицуулагч байгууллагуудын тогтоосон стандарт, шаардлагын хүрээнд компанийн засаглалын зарчмуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Компанийн засаглалын хүрээнд бид үйл ажиллагааны ил тод байдал, хариуцлагын тогтолцоог төлөвшүүлэх, шийдвэр гаргах үйл явцыг илүү үр ашигтай, хяналттай болгоход анхаарч, Гүйцэтгэх удирдлагын түвшинд хяналт тавих Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ, Удирдлагын багийн үйл ажиллагааг шаталсан бүтэц, чиг үүргийн дагуу хэрэгжүүлж байна.

Манай байгууллага нь компанийн засаглалын зарчмуудыг хэрэгжүүлж, оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах, зээлийн үйл ажиллагааны эрсдэлийг оновчтой удирдах, үйл ажиллагааны ил тод, тогтвортой байдлыг хангах зорилгоор дотоод хяналт, ёс зүйн дүрэм, харилцагчийн мэдээллийн хамгаалалт зэрэг чиглэлээр баримт бичиг, журам, бодлого боловсруулан хэрэгжүүлдэг.

2025 оны эхний хагас жилийн байдлаар компанийн засаглалын хүрээнд байгууллагын засаглал, нийгмийн хариуцлага, үйл ажиллагааны ил тод байдлыг хангасан талаарх мэдээллийг олон нийтэд тогтмол тайлагнаж, харилцагч, хамтрагчидтайгаа итгэлцэл, хариуцлагад тулгуурласан харилцааг бэхжүүлэн ажиллаж байна.

ТУЗ-ийн үйл ажиллагаа

“Кредитех СТМ ББСБ” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) нь компанийн засаглалын зарчмыг хэрэгжүүлэх, стратегийн зорилтыг тодорхойлох, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих, ил тод, үр ашигтай удирдлагыг хангах чиг үүрэгтэйгээр ажиллаж байна.

ТУЗ нь компанийн дүрэм, дотоод журам болон зохицуулагч байгууллагаас гаргасан холбогдох хууль, журмын хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг ба компанийн урт хугацааны өсөлт, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах, тайлагналын ил тод байдлыг бүрдүүлэхэд чиглэсэн бодлого, шийдвэрийг гаргаж, хэрэгжилтэд тогтомол хяналт тавьж байна.

ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагаа

“Кредитех СТМ ББСБ” ХХК нь компанийн засаглалын үр нөлөөг дээшлүүлэх, хяналтын тогтолцоог сайжруулах, шийдвэр гаргалтыг мэргэжлийн түвшинд дэмжих зорилгоор Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд дараах таван хороог байгуулан, тогтмол үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

Аудитын хороо

Байгууллагын дотоод хяналт, тайлагналын бодит байдал, дотоод болон гадаад аудитын дүгнэлтэд үндэслэн үнэлгээ, зөвлөмж гаргах, аудитын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллаж байгаа бөгөөд даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Ш.Цэрэндаваа ажиллаж байна.

Нэр дэвшүүлэх хороо

Компанийн засаглалын зарчим, хариуцлагатай удирдлагыг төлөвшүүлэх, ТУЗ-ийн гишүүдийг нэр дэвшүүлэх, үнэлэх, хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих чиглэлээр ажиллаж байгаа ба даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Баярмаа ажиллаж байна.

Цалин, урамшууллын хороо

Гүйцэтгэх удирдлагын цалин, урамшууллын бодлогыг тодорхойлох, зохистой түвшинг тогтоох, урамшууллын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, холбогдох саналыг ТУЗ-д танилцуулдаг ба даргаар ТУЗ-ийн дарга Д.Цолмон ажиллаж байна.

Эрсдэлийн удирдлагын хороо

Зээлийн болон үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээ, хяналт, эрсдэлийн удирдлагын бодлого, журмын хэрэгжилтэд хяналт тавих, эрсдэлийн түвшинг бууруулах талаар санал зөвлөмж боловсруулахад ТУЗ-ийн хараат бус гишүүн Ш.Цэрэндаваа даргалан ажиллаж байна.

Тогтвортой байдлын хороо

Зээлийн болон үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээ, хяналт, эрсдэлийн удирдлагын бодлого, журмын хэрэгжилтэд хяналт тавих, эрсдэлийн түвшинг бууруулах талаар санал зөвлөмж боловсруулах чиглэлээр ажиллаж байна. Хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Т.Батзул ажиллаж байна.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүн



Д.ЦОЛМОН
ТУЗ-ийн Дарга

Мони Маркет Фанд ХХК
ТУЗ-ийн Дарга



Б.БАЯРМАА
ТУЗ-ийн Хараат
бус гишүүн

Тэрбум Мод Сан
Гүйцэтгэх захирал



Т.БАТЗУЛ
ТУЗ-ийн Хараат
бус гишүүн

Микро Кредит ББСБ ХХК
ТУЗ-ийн дарга



Ш.ЦЭРЭНДАВАА
ТУЗ-ийн Хараат
бус гишүүн

Кредитех СТМ ББСБ ХХК
Санхүү эрхэлсэн захирал



Х.АМГАЛАНБАЯР
ТУЗ-ийн Хараат
гишүүн

Кредитех СТМ ББСБ ХХК
Гүйцэтгэх захирал

“Кредитех СТМ ББСБ” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн стратегийн бодлого, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, засаглалын зарчмыг хэрэгжүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллаж байна. ТУЗ нь компанийн үйл ажиллагааны гол шийдвэрүүдийг хэлэлцэн батлах, эрсдэлийн удирдлага, хяналт-шинжилгээ, цалин урамшууллын бодлогын хэрэгжилтэд хяналт тавьж, байгууллагын урт хугацааны хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд манлайлан оролцож байна.